

ГЭРЛЭЛТИЙН ЦЭВЭР ХҮСНЭГТИЙН ТООЦООЛОЛ: АНХНЫ ГЭРЛЭЛТ ДЭХ ХҮЙСИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Баатарын Наранчимэг, МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны салбарын Эдийн засгийн тэнхимийн ахлах багш, докторант

Хураангуй

Монгол улсын хүн ам орон сууцны 2020 оны тооллогын мэдээллийг ашиглан Монгол улсын хүн амын анхны гэрлэлт дэх хүйсийн ялгаатай байдлын шинжилгээг гэрлэлтийн цэвэр хүснэгт ашиглан тооцлоо. Монгол улсын хүн амын гэрлэлтийн хэв маягт хүйсийн ялгаатай байдал нэлээд ажиглагдаж байгаа ба энэ нь нас баралтыг тооцсон гэрлэлтийн цэвэр хүснэгтээр илүү тодорхой харагдаж байгаа юм. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 2 насаар эрт гэрлэж байна. Хэдий тийм ч Монгол эрэгтэйчүүд насан туршийн амьдралынхаа дунджаар 41.6 хувийг огт гэрлээгүйгээр өнгөрүүлж байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 1.2 дахин өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь насны бүлэг дэх гэрлэлтийн хэв маяг, нас баралт дах хүйсийн ялгаатай байдалтай холбоотой байгааг шинжилгээгээр харуулав.

Түлхүүр үгс: Гэрлэлт, анхны гэрлэлтийн дундаж нас, гэрлэх магадлал, ганц бие амьдрах хүлээгдэж буй хугацаа, ганц бие амьдралын хугацаа, анхны гэрлэлтээс хойш амьдрах дундаж хугацаа, гэрлэлтийн цэвэр хүснэгт

Abstract

The Population and Housing Census 2020 data of Mongolia was used to analyze the gender differences in the first marriages of the Mongolian population using a net nuptiality table. There are significant gender differences in the marriage patterns of the Mongolian population, as evidenced by the net marriage table that calculates mortality. While women marry on average 2 years earlier than men, it is an average of 41.6 percent for men remaining unmarried, 1.2 times more than the women. From the analysis, this is due to age specific nuptiality pattern and mortality gender differences.

Keywords: Nuptiality, singulate mean age at marriage, probability of marriage, expectancy of single life, lifetime spent as single, average years of life after marriage, net nuptiality table.

1. УДИРТГАЛ

1.1. Үндэслэл

Гэрлэлт бол аливаа улс орны хүн амын шинж байдлыг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг юм (Roy & Choudhury, 2020; ХАССТ, 2006). Гэрлэх үйл явц нь үндэсний уламжлалтай холбоотой байдгаас түүхийн богино хугацаанд эрс өөрчлөлт ордоггүй боловч аливаа улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор зарим онцлог өөрчлөлтүүд гарсаар байдаг (Үндэсний статистикийн газар, 2003). Түүнчлэн гэрлэлтийн хэв маяг дахь өөрчлөлтүүд нь нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн өөрчлөлтүүдэд эргээд хүчтэй нөлөөлдөг харилцан хамааралтай тул нийгмийн үзэгдлүүдийг цаг хугацааны явцад

хэрхэн өөрчлөгдөж, хөгжиж байгааг ойлгоход гэрлэлтийн судалгаа чухал ач холбогдолтой (NISR, 2014; Roy & Choudhury, 2020).

Аливаа улс орны хүн амын гэрлэлтийн хэв маягийг судлах, хэмжих олон аргачлал байдгаас хамгийн энгийн, тооцоход хялбар, түгээмэл ашиглагддаг арга бол Хажнал¹-ын анхны гэрлэлтийн дундаж нас тооцох арга юм. Гэвч анхны гэрлэлтийн насны хэв маяг хугацаагаар болон үелрэлээр өөрчлөгдөж байгаа эсэхийг тодорхойлоход Хажналын

¹ Хажнал (1953) бол Их Британийн хүн ам зүйч, судлаач бөгөөд гэрлэлтийн цаг хугацааг тооцоолох аргачлалыг боловсруулсан нь өдгөө түгээмэл ашиглагдсаар байна. Түүний боловсруулсан арга нь тухайн тооллогын үед ганц бие байсан хүмүүсийн хувийн жинд үндэслэдэг бөгөөд 50 насандаа гэрлэсэн байх магадлалыг шууд бус аргаар тооцон таамаглаж, эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн 50 хүртэлх насандаа ганц бие амьдрах дундаж хугацааг тооцоолдог.

арга хангалттай мэдээлэл өгч чаддаггүй (Sardon, 1994). Харин Хажналын аргын дутагдалтай байдлыг нөхөх, шинжилгээний үр дүнг нарийвчлах зорилгын үүднээс боловсруулагдаж, хөгжиж ирсэн гэрлэлтийн талаар төвлөрсөн, цогц мэдээлэл өгч чаддаг аргачлал бол гэрлэлтийн хүснэгт зохиох арга юм.

Гэрлэлтийн хүснэгт нь гэрлэлтийн хандлага ба хэв маягийн шинжилгээнд ашиглагдаж ирсэн хамгийн эртний бөгөөд хамгийн боловсронгуй арга техник гэж Малакер (1978), Кумар (1967) нар тэмдэглэжээ. Гэрлэлтийн хүснэгтийг насжилтын хүснэгтийн аргачлалаар зохиодог. Гэрлэлтийн хүснэгт зохиох замаар хүн ам ганц бие байх үеэс гэрлэх хүртэлх шилжилтийн хэв маягийг нас, хүйсээр судалдаг шинжилгээ гэрлэлтийн судалгааны томоохон чиглэлийг тодорхойлдог. Хэрэв насны бүлэг нэмэгдэх тусам ганц бие хүмүүсийн тоо хасагдах үйл явц зөвхөн гэрлэлтээс хамаарна гэсэн төсөөллөөр хүснэгт зохиовол гэрлэлтийн ерөнхий хүснэгт гэж нэрлэнэ. Харин гэрлэлтийн цэвэр хүснэгт нь нас баралтыг ганц бие хүмүүсийн насаар шилжин хасагдах үйл явцад нөлөөлөгч хүчин зүйлийн нэг гэж давхар тооцоолол хийдгээрээ гэрлэлтийн ерөнхий хүснэгтээс ялгаатай. Гэрлэлтийн ерөнхий хүснэгтийг нас баралтын ялгаатай хэв маягтай бүс нутгуудын гэрлэлтийн түвшин, хэв маягийг харьцуулах зорилготой судалгаанд (хүн амын тоо насаар шилжин хасагдах үйл явц дахь нас баралтын нөлөөг саармагжуулж) ашиглахад тохиромжтой. Гэрлэлтийн цэвэр хүснэгт бол нас баралтыг тооцож гэрлэлтийн түвшин, хэв маягийг илүү нарийвчлалтай тооцдог загвар тул голдуу хүн амын нөхөн үржихүйн хандлагыг судлах, төсөөлөх судалгаа шинжилгээнд ашиглагддаг.

Гэрлэлтийн цэвэр хүснэгт нь судлагдаж буй хүн амын хувьд ганц бие хүмүүсийн гэрлэх магадлал, тухайн наснаас цааш ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа, *анхны гэрлэлтийн дундаж нас*, анхны гэрлэлтээс хойш амьдрах дундаж хугацаа зэргээс гадна хүн амьдралынхаа нийт хугацааны мөчлөгийн хичнээн хувийг *ганц бие амьдралаар туулж өнгөрүүлдэг талаарх гэрлэлтийн хугацаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг тодорхойлоход тусалдаг* (Roy & Choudhury, 2020).

1.2. Судлагдсан байдал

Монгол улсын хүн амын гэрлэлтийн хугацаатай холбоотой судалгаанд анхны гэрлэлтийн ганцаарчилсан дундаж насны тооцоолол голлох байр суурь эзэлдэг. Түүнчлэн анхны гэрлэлтийн дундаж насны талаарх судалгаа, тэдгээрийн хэрэглээг дурдвал зөвхөн тооллогын мэдээлэлд үндэслэсэн сэдэвчилсэн судалгаануудад (Б.Батмөнх нар, 2011; Үндэсний статистикийн газар, 2002) Хажналын аргаар тооцож дүгнэлт хийсэн байдаг. Гэрлэлтийн талаарх бусад судалгаа, шинжилгээний ажилд хүн амын гэрлэх насны талаарх мэдээллийг өөрөөр тооцож ашиглах нь ховор байна.

“Анхны гэрлэлтийн дундаж насыг тооцоолох аргачлалын харьцуулсан шинжилгээ” сэдэвт ажил (Б.Наранчимэг, 2020)-д гэрлэлтийн ерөнхий хүснэгт ба гэрлэлтийн цэвэр хүснэгтийг 1989, 2000, 2010 оны ХАОСТ-ын мэдээллүүдэд үндэслэн зохиосон нь Монголын хүн амын гэрлэлтийн насны шилжилтийн хэв маягийг тодорхойлох судалгаанд аргазүйн талаас томоохон хувь нэмэр оруулсан бүтээл болсон юм. Энэхүү судалгаа нь анхны гэрлэлтийн дундаж насыг ялгаатай арга зүйгээр харьцуулах зорилготой хийгдсэн тул хүн амын гэрлэлтийн насны шилжилтийн хэв маягийн талаарх дэлгэрэнгүй тайлбар хийгдээгүйг дурдах нь зүйтэй.

1.3. Зорилго, зорилтууд

Судалгаагаар гэрлэлтийн цэвэр хүснэгт зохиож, түүнийг ашиглан Монгол улсын хүн амын гэрлэлтийн хугацаатай холбоотой сонгосон үзүүлэлтүүд хүйсээр ялгаатай эсэхийг тодорхойлох зорилго дэвшүүлсэн. Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- ✓ Тооллогоор өгөгдсөн ганц бие хүн амын мэдээлэл болон насны бүлгээр өгөгдсөн нас баралтын мэдээлэлд тулгуурлан эрэгтэй, эмэгтэй хүн амын хувьд тус тусад нь гэрлэлтийн цэвэр хүснэгт зохиох;
- ✓ Гэрлэлтийн цэвэр хүснэгтийн мэдээллийг ашиглан гэрлэлтийн хугацааны талаарх үзүүлэлтүүд (*анхны гэрлэлтийн дундаж нас, гэрлэх магадлал, ганц бие амьдрах хүлээгдэж буй хугацаа, ганц бие амьдралын хугацаа, анхны гэрлэлтээс хойш амьдрах дундаж хугацаа гэх мэт*)-ийг тооцож хүйсээр харьцуулах;

1.4. Ач холбогдол

Судалгаагаар гэрлэлтийн насны бүлгээр шилжих хэв маягийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүйс тус бүрт тооцож, гэрлэлтийн хэв маяг хугацааны хувьд хүйсээр ялгаатай болохыг нарийвчлан тодорхойлсон нь Монгол улсын гэрлэлтийн судалгааны салбарт онол, арга зүйн чухал ач холбогдолтой. Түүнчлэн сэдэвтэй холбоотой эрдэм шинжилгээний дараа дараагийн ажлуудад судалгааны үр дүнг ашиглах боломжтой.

2. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ

2.1. Ойлголт, тодорхойлолт

Анхны гэрлэлтийн дундаж нас: 15-19 насны бүлэг дэх огт гэр бүл болж байгаагүй хүн амын хувьд анх удаа гэрлэх хүртэл ганцаар амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа.

Анхны гэрлэлтээс хойш амьдрах дундаж хугацаа: Огт гэр бүл болоогүй хүн ам ганц бие амьдралаа дуусгавар болгож анх удаа гэрлэснээс хойш амьд явах хүлээгдэж буй дундаж хугацаа.

Гэрлэх /эсвэл нас барах/ цэвэр магадлал: Тухайн насны бүлэг дэх ганц бие хүн ам дараагийн насны бүлэгт шилжихэд гэрлэсэн эсвэл нас барсан байх магадлал. Энэ нь тухайн насанд буй ганц бие хүн амын тоо дараагийн насанд шилжихэд гэрлэх эсвэл нас барах үзэгдлийн аль нэгээс болж буурна гэсэн төсөөлөлтэй холбоотой. Үүнийг цаашид **гэрлэх цэвэр² магадлал гэсэн нэршилээр ашиглана.**

Гэрлэлтийн цэвэр, хураангуй хүснэгт: Ганц бие хүн амын тоо гэрлэх үзэгдлээс гадна нас барах үзэгдлээс болж дараагийн насанд шилжихэд цөөрнө гэсэн төсөөлөл дээр үндэслэсэн гэрлэлтийн хүснэгтийг гэрлэлтийн цэвэр хүснэгт гэнэ. Гэрлэлтийн хүснэгтийг 15-50 насны хүн амын хувьд зохиохдоо нэг насаар бус, харин 5 насны бүлгээр зохиосон тохиолдолд гэрлэлтийн хураангуй хүснэгт болно.

² Огт гэр бүл болоогүй хүн амын дараагийн насанд шилжихдээ гэрлэх магадлалыг гэрлэлтийн ерөнхий хүснэгт, гэрлэлтийн цэвэр хүснэгтийн аль алинд тооцох боломжтой. Гэрлэлтийн цэвэр хүснэгт дэх гэрлэх магадлалын тооцоолд нас баралтыг оруулж тооцоноор гэрлэлтийн ерөнхий хүснэгт дэх гэрлэх магадлалаас ялгаатай магадлал тодорхойлогддог. Тиймд гэрлэлтийн судалгаанд нас баралтыг тооцсон гэдэг санаагаар **гэрлэх цэвэр магадлал** гэсэн нэр томъёог ашигладаг.

Ганц бие амьдрах хүлээгдэж буй хугацаа: Тухайн насны бүлэг дэх огт гэрлээгүй байгаа хүн ам цаашид үргэлжлүүлэн ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа.

Ганц бие амьдралын хугацаа: Хүн төрсөн цагаасаа хойш нийт амьдрах хугацааныхаа хэдэн хувийг анх удаа гэрлэх хүртлээ туулан өнгөрүүлж байгааг илэрхийлсэн үзүүлэлт.

2.2. Мэдээллийн эх үүсвэр

Хүн амын гэрлэлтийн байдлын насны тархалтын мэдээллийг Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын мэдээ (ҮСХ, 2020)-нээс авч ашигласан. Харин хүн амын нас баралтын хандлагыг 2010-2019 оны хоорондох нийт нас баралтын дунджаар тодорхойлсон бөгөөд холбогдох мэдээллийг www.1212.mn цахим мэдээллийн сан (ҮСХ, 2020)-с авсан.

2.3. Гэрлэлтийн цэвэр хүснэгт

Гэрлэлтийн цэвэр, хураангуй (5 насны бүлгээрх мэдээнд үндэслэсэн) хүснэгт зохиоход хүйс тус бүрийн хувьд 5 насны бүлгээр өгөгдсөн 15-49 насны огт гэр бүл болоогүй хүн амын тоо; 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын тоо; 15-49 насны хүн амын насны бүлэг дэх нас баралтын тоонуудыг ашигласан.

Энд тухайн насны бүлэг тус бүрт огт гэрлээгүй байгаа хүн амын тоо дараагийн насны бүлэгт шилжихдээ гэрлэх эсвэл нас барах аль нэг үзэгдлийн улмаас буурна. Энэхүү бууралтад шилжих хөдөлгөөн нөлөөгүй, өчүүхэн бага буюу байхгүй гэсэн төсөөллүүдийг дэвшүүлсэн. Түүнчлэн 15-49 насны бүлгийн хүн амын хувьд л анхны гэрлэлт тохиолдоно гэж үзсэн.

Насны бүлэг тус бүрт өгөгдсөн огт гэр бүл болоогүй хүн амын харьцаанд үндэслэн гэрлэх магадлалыг, насны бүлэг дэх нас баралтын мэдээлэлд үндэслэн нас барах магадлалыг тодорхойлсноор хийсвэр хүн амын хувьд цаашид үргэлжлүүлэн ганц бие амьдрах хүлээгдэж буйг хугацааг тооцох нь гэрлэлтийн хүснэгтийн гол зорилго билээ.

Гэрлэлтийн хүснэгтээс цаашид үргэлжлүүлэн ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацааг насны бүлэг тус бүрийн хувьд шууд авч ашигладаг. Харин анхны гэрлэлтээс хойш амьдрах дундаж хугацаа болон ганц бие амьдралын нийт хугацааг 0-4 насны бүлгийн хүн амын хувьд харгалзаж буй цаашид

үргэлжлүүлэн ганц бие амьдрах хүлээгдэж буй хугацаа ($e_{0.4}^{0.1}$)-г ашиглан дараах аргачлалаар тодорхойлсон. Үүнд:

Анхны гэрлэлтээс хойш амьдрах дундаж хугацаа (жил) = Дундаж наслалт – $e_{0.4}^{0.1}$


Ганц бие амьдралын нийт хугацаа

$$(\%) = \frac{e_{0.4}^{0.1}}{\text{дундаж наслалт}} * 100$$

3. ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монголын хүн амын гэрлэлтийн цэвэр хүснэгтийг хүйс тус бүрт тооцсон (Хавсралт хүснэгт 1). Хүснэгт зохиох явцад тухайн насны бүлэг дэх огт гэрлээгүй хүн ам дараагийн насны бүлэгт шилжихдээ гэрлэх цэвэр магадлалыг тооцож Зураг 1-т насны бүлэг, хүйсээр харьцуулан харуулав.

Зураг 1. Гэрлэх цэвэр магадлал, насны бүлэг ба хүйсээр, Монгол улс, 2020 он



Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны тооллогын мэдээнд үндэслэн тооцсон гэрлэлтийн цэвэр хүснэгт, зохиовчийн тооцоо

Огт гэрлээгүй буюу ганц бие хүн амын хувьд дараагийн насны бүлэгт шилжихдээ гэрлэх цэвэр магадлал 15-29 насны хооронд нэмэгдэх хандлагатай боловч 29 наснаас хойш буурах зүй тогтол ажиглагдаж байна. Гэрлэх цэвэр магадлалын ерөнхий зүй тогтол 15-44 насанд хүйсийн хувьд онцын ялгаагүй боловч 15-24 насны залуу эмэгтэйчүүдийн гэрлэх цэвэр магадлал ижил насны эрэгтэйчүүдийнхээс (0.1 пунктээр) илүү өндөр байв. Харин 25-44 насны хүн амын гэрлэх цэвэр магадлалд хүйсийн ялгаа өчүүхэн бага буюу зөрүүтэй байдал бараг ажиглагдаагүй. Нөхөн үржихүйн хожуу (45-49) насандаа анх удаа гэрлэх цэвэр магадлал эрэгтэйчүүдэд өмнөх (40-44) насны бүлгээс бараг 1.6 дахин нэмэгдсэн бол эмэгтэйчүүдийн гэрлэх цэвэр магадлал 40-44 насны бүлгийнхтэй харьцуулахад дөнгөж 0.01 пунктээр л нэмэгдэх хандлагатай байна. Нөхөн үржихүйн хожуу насны бүлгийн хүн амын хувьд гэрлэх цэвэр магадлал нь гэрлэх үзэгдлээс илүүтэй нас баралтаас хамаарч нэмэгдсэн байх боломжтой. Энэ нь хүйсээр ялгаатай байж болно.

Тиймд насны бүлэг тус бүр дэх нас барах цэвэр³ магадлалыг хүйсээр зэрэгцүүлж авч үзэх нь зүйтэй.

Огт гэрлээгүй эрэгтэй, эмэгтэй хүн амын нас барах цэвэр магадлалыг насны бүлгээр Зураг 2-т харуулав.


Зургаас харахад бүх насны бүлэгт ганц бие эрэгтэй хүн амын нас барах цэвэр магадлал эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа ба насны бүлэг ахих тусам нас барах цэвэр магадлал дахь хүйсийн зөрүүтэй байдал нэмэгдэх хандлагатай байна.

Хэдийгээр 25-44 насны хүн амын хувьд гэрлэх цэвэр магадлалд хүйсийн ялгаатай байдал бараг ажиглагдаагүй боловч нас барах цэвэр магадлал дахь зөрүү нэмэгдэж байгаа нь тухайн насны бүлгүүд дэх эрэгтэй эмэгтэй хүн амын ганц бие амьдралаа үргэлжлүүлэх хүлээгдэж буй дундаж хугацаа хүйсээр ялгаатай болоход нөлөөлнө. Энэхүү

³ Гэрлэлтийн ерөнхий хүснэгт дэх гэрлэх магадлал болон нийт хүн амын насны бүлэг дэх нас баралтын хандлагыг ашиглан гэрлэлтийн цэвэр хүснэгтэд шууд бусаар тооцож гаргасан нас барах магадлалыг **нас барах цэвэр магадлал** гэж нэрлэдэг.

дүгнэлтийг нотлохын тулд ганц бие амьдрал хугацааг хүйсээр харьцуулах хэрэгтэй. дуусгавар болох хүлээгдэж буй дундаж

Зураг 2. Нас барах цэвэр магадлал, насны бүлэг ба хүйсээр, Монгол улс, 2010-2019 он




Эх үүсвэр: МУ-ын Хүн ам орон сууцны 2020 оны тооллогын мэдээнд үндэслэн тооцсон гэрлэлтийн цэвэр хүснэгт, зохиогчийн тооцоо

Зураг 3-т гэрлэлтийн цэвэр хүснэгт дэх гэрлэх эсвэл нас барах хүртлээ ганц бие амьдрах хүлээгдэж буй хугацааны мэдээллийг насны бүлэг, хүйсээр харьцуулан харууллаа.

Өсвөр (15-19) насны залуучуудын цаашид ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа 2020 оны байдлаар хөвгүүдийн хувьд 13.2 жил, охидын хувьд 11.3 жил байна. Уг үзүүлэлт 20-24 насны залуусын хувьд 15-19 насны хүн амынхаас 2.7-3.7 пунктээр бага буюу 20-24 насны эрэгтэйчүүд цаашид дунджаар 9.5 жил, эмэгтэйчүүдэд 8.6 жил ганц бие амьдрах

хүлээлттэй байна. Зургаас харахад 25-49 насны эмэгтэйчүүдийн ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа ижил насны эрэгтэйчүүдийнхээс 0.4-2.2 жилээр урт байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн эмэгтэйчүүдийн хувьд 20-39 насанд, эрэгтэйчүүдийн хувьд 25-39 насанд ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа нас ахих тусам нэмэгдэх хандлагатай байна. Харин 40 наснаас хойш ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа нас ахих тусам багасаж буй зүй тогтолд хүйсийн ялгаа ажиглагдсангүй.

Зураг 3. Ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа, насны бүлэг ба хүйсээр, Монгол улс, 2020 он



Эх үүсвэр: МУ-ын Хүн ам орон сууцны 2020 оны тооллогын мэдээнд үндэслэн тооцсон гэрлэлтийн цэвэр хүснэгт, зохиогчийн тооцоо

Зураг 1, Зураг 2, Зураг 3-с дүгнэхэд 15-24 насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад эрт гэрлэж байгаагаас ганц бие амьдрах хүлээгдэж буй хугацаа эрэгтэйчүүдийнхээс бага байна. Түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүн амын хувьд гэрлэх цэвэр магадлал 25 нас хүртэл нэмэгдэж байгаа нь тухайн насны бүлэг дэх огт гэрлээгүй хүн амын ганц бие амьдралаа үргэлжлүүлэх хүлээгдэж буй хугацаа буурахад нөлөөлж байгаа юм. Харин 25 нас хүртлээ огт гэрлээгүй, ганц бие амьдарсан хүн амын хувьд цаашид гэрлэх цэвэр магадлал хүйсээр онцын ялгаагүй боловч нас барах цэвэр магадлал эрэгтэйчүүдэд өндөр байгаа нь ганц бие амьдрах хүлээгдэж буй хугацаа эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдийнхээс богино байхад нөлөөлсөн нь тодорхой байна.

Гэрлэлтийн хүснэгт зохиосноор анхны гэрлэлтийн дундаж насыг тодорхойлохоос гадна гэрлэлтийн хугацаатай холбоотой нэмэлт мэдээллүүдийг тооцох боломжтой болдог.

Гэрлэлтийн цэвэр хүснэгтийн мэдээлэлд үндэслэн тооцсон гэрлэлтийн хугацааны талаарх сонгосон үзүүлэлтүүдийг хүйсээр зэрэгцүүлж Хүснэгт 1-д харуулав.

Шинжилгээний дүнгээс харвал 2020 оны байдлаар 15 ба түүнээс дээш настай Монгол эрэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас 28.2, эмэгтэйчүүдийнх 26.3 байна. Дэлхийн ихэнх улс орнуудад ажиглагддаг зүй тогтлын дагуу Монгол эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага (1.9 жилээр бага) байна.

Хүснэгт 1. Гэрлэлтийн хугацааны талаарх сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр, Монгол улс, 2020 он

Сонгосон үзүүлэлтүүд	Эрэгтэй	Эмэгтэй
Анхны гэрлэлтийн дундаж нас	28.2	26.3
Анхны гэрлэлтээс хойш амьдрах дундаж хугацаа	38.9	50.1
Ганц бие амьдралын нийт хугацаа (%)	41.4	34.0
<i>Төрөлтөөс тооцсон дундаж наслалт*</i>	66.4	76.0

Эх сурвалж: МУ-ын 2020 оны ХАОСТ-ын мэдээнд үндэслэн тооцсон гэрлэлтийн цэвэр хүснэгтэд үндэслэсэн тооцоолол

* - www.1212.mn

Монгол эрэгтэйчүүд анхны гэрлэлтээсээ хойш дунджаар 38.9 жил амьдардаг бол эмэгтэйчүүд (50.1 жил) тэднээс 11.2 жилээр удаан хугацаанд амьдардаг болох нь тооцооллын үр дүнгээс харагдлаа. Энэ үзүүлэлт нь гэр бүл салах, дахин гэрлэх, бэлэвсрэх амьдралын мөчлөгтэй холбоотой хугацааны мэдээллийг тусган харуулдаггүй. Монгол эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй эрт нас барах хандлагатай байдгаас дундаж наслалт дахь хүйсийн ялгаа 10 орчим насны зөрүүтэй болсон нь анхны гэрлэлтээс хойш амьд явах хугацааны хүйсийн зөрүүтэй байдалд шууд нөлөөлж байна.

Гэрлэлтийн цэвэр хүснэгтээс тооцож болдог бас нэгэн сонирхолтой статистик бол амьдралынхаа нийт хугацааны хичнээн хувийг ганц бие өнгөрөөж байгаа талаарх мэдээлэл юм. Монгол эрэгтэйчүүд төрсөн цагаасаа хойш туулж өнгөрүүлэх амьдралынхаа нийт хугацааны 41.4 хувийг, харин эмэгтэйчүүд 34 хувийг нь огт гэр бүл болоогүй, ганц бие

байхдаа туулан өнгөрүүлж байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү цөөн жил ганц бие амьдарч, илүү удаан хугацаанд хосын амьдралаар хорвоог туулдаг гэсэн үг биш юм. Монгол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 2 жилийн өмнө гэрлэдэг боловч 10 орчим жилээр урт насалж байгаа тул амьдралынхаа (14.7 хувь) сүүлийн жилүүдийг бэлэвсэн ганц бие амьдралаар туулдаг болохыг илэрхийлж байна.

4. ДҮГНЭЛТ

Судалгаагаар гэрлэлтийн цэвэр хүснэгт зохиож, Монгол улсын хүн амын гэрлэлтийн хугацааны талаарх үзүүлэлтүүд хүйсээр ялгаатай эсэхийг тодорхойлох үндсэн зорилго дэвшүүлсэн.

Шинжилгээний үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- ✓ Эрэгтэй (28.2) хүн амтай харьцуулахад эмэгтэйчүүд (26.3) дунджаар 2 насаар эрт гэрлэж байна.
- ✓ Гэрлэх цэвэр магадлал 15-29 насныхны хувьд насны бүлэг бүрт хүйс харгалзахгүйгээр нэмэгдээд 30-наас хойш буурах хандлагатай байна. Харин эмэгтэйчүүд 25 нас хүртлээ, эрэгтэйчүүд 30 нас хүртлээ огт гэр бүл болоогүй тохиолдолд эсрэгээрээ гэрлэх магадлал буурч, залуу насныхантай харьцуулахад цаашид харьцангуй удаан хугацаанд ганц бие амьдралаа үргэлжлүүлэхээр байна.
- ✓ Ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа хүйсээр ялгаатай байна. Тодруулбал, 25 хүртэлх насны залуу хүн амын хувьд эрэгтэйчүүдийн ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаа эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс эрт гэрлэж байгаатай холбоотой. Харин 25 нас (эрэгтэй 30 нас) хүртлээ ганц бие амьдарсан залуусын хувьд 25 наснаас хойш гэрлэх цэвэр магадлалд хүйсийн ялгаа байхгүй боловч нас барах цэвэр магадлал дахь хүйсийн зөрүүтэй байдлаас шалтгаалан ганц бие амьдрах хүлээгдэж буй дундаж хугацаанд хүйсийн зөрүүтэй байдал үүсч эмэгтэйчүүд илүү удаан хугацаанд ганц бие амьдрах хүлээлттэй болж байна.
- ✓ Монгол эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хоёр жилээр хожуу гэрлэдэг боловч 10 орчим жилийн өмнө нас барж байгаа тул огт гэрлээгүй байхдаа туулж өнгөрүүлэх амьдралын нийт хугацаань эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.2 дахин их буюу төрснөөс хойш амьдрах нийт хугацааны 41.4 хувийг эзэлж байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд насан туршийн амьдралынхаа бараг 1/3-тэй тэнцэх (34 хувь) хугацааг огт гэр бүл бололгүй амьдарч байгаад анхны гэрлэлтээсээ хойш дунджаар 50.1 жил амьдарч байгаа нь эрэгтэй (38.9 жил) хүн амтай харьцуулахад 11.2 жилээр урт хугацаа болж байгаа юм. Ийнхүү нас баралтын хүйсийн зөрүүтэй байдлаас шалтгаалан эмэгтэйчүүд амьдралынхаа нийт хугацааны дунджаар сүүлийн 14.7 хувьд бэлэвсэн амьдрах хүлээлттэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- NISR. (2014). *Marital Status and Nuptiality* (Report). Retrieved from National Institute of Statistics of Rwanda website: http://www.imis.gov.rw/scripts/publication/reports/Fourth Rwanda Population and Housing Census Marital status_ nuptiality.pdf
- Roy, R., & Choudhury, L. (2020). Net Nuptiality Tables for Males and Females of India and some of its Selected States (2011). *Journal of Humanities and Social Sciences Studies*, 2(1), 118–140. Retrieved from www.jhsss.org
- Sardon, J.-P. (1994). Probabilities, frequencies and events. *Population*, 6(7), 151–157. Retrieved from https://www.researchgate.net/publication/11118580_Probabilities_frequencies_and_events/stats
- Б. Батмөнх, Д.Нарантуяа, Б.Энх-Амгалан, Д.Хишигт, & Б.Оюун-Эрдэнэ. (2011). *Хүн ам орон сууцны тооллого, 2010: Өрх гэр бүлийн байдал* (Сэдэвчилсэн судалгаа). Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.
- Б.Наранчимэг. (2020). Анхны гэрлэлтийн дундаж насыг тооцоолох аргачлалын харьцуулсан шинжилгээ. *Монголын Хүн Амын Сэтгүүл*, 30(2), 19–32.
- Үндэсний статистикийн газар. (2002). *Хүн ам орон сууцны тооллого, 2000: Хүн амын гэрлэлтийн байдал* (Сэдэвчилсэн судалгаа). Улаанбаатар: Ти энд Юү принтинг.
- Үндэсний статистикийн газар. (2003). *Монгол Улсын хүн ам хорьдугаар зуунд* (Эмхтгэл). Улаанбаатар: Үндэсний статистикийн газар.
- Үндэсний статистикийн хороо. (2020). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Retrieved from <https://www.1212.mn/>
- Үндэсний статистикийн хороо. (2020). *Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн*. Retrieved from <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report.pdf&ln=Mn>
- ХАССТ. (2006). *Хүн ам зүйн үндсэн асуудлууд* (сурах бичиг). Улаанбаатар.

ХАВСРАЛТУУД

Хавсралт хүснэгт 1а. Цэвэр гэрлэлтийн хүснэгт - ЭРЭГТЭЙ хүн ам (Монгол, 2020 он)

Нас x (1)	${}_5n'_x$ (2)	${}_5q'_x$ (3)	l'_x (4)	${}_5d'_x$ (5)	${}_5N'_x$ (6)	${}_5L'_x$ (7)	T'_x (8)	e_x^{0r} (9)
0-4	-	0.0237	100 000	2 373	-	494 068	2 748 017	27.48
5-9	-	0.0025	97 627	247	-	487 518	2 253 949	23.09
10-14	-	0.0029	97 380	287	-	486 183	1 766 431	18.14
15-19	0.1065	0.0053	97 093	516	10 344	458 316	1 280 247	13.19
20-24	0.3894	0.0072	86 233	618	33 581	345 668	821 932	9.53
25-29	0.4981	0.0082	52 034	424	25 917	194 319	476 264	9.15
30-34	0.4187	0.0129	25 693	332	10 758	100 742	281 945	10.97
35-39	0.2939	0.0211	14 603	308	4 292	61 515	181 204	12.41
40-44	0.1830	0.0331	10 003	331	1 831	44 608	119 689	11.97
45-49	0.2689	0.0481	7 841	377	2 108	32 990	75 080	9.58

Хавсралт хүснэгт 1б. Цэвэр гэрлэлтийн хүснэгт - ЭМЭГТЭЙ хүн ам (Монгол, 2020 он)

Нас x (1)	${}_5n'_x$ (2)	${}_5q'_x$ (3)	l'_x (4)	${}_5d'_x$ (5)	${}_5N'_x$ (6)	${}_5L'_x$ (7)	T'_x (8)	e_x^{0r} (9)
0-4	-	0.0191	100 000	1 912	-	495 220	2 582 054	25.82
5-9	-	0.0017	98 088	167	-	490 023	2 086 833	21.28
10-14	-	0.0017	97 921	165	-	489 192	1 596 810	16.31
15-19	0.2054	0.0025	97 756	241	20 078	437 982	1 107 619	11.33
20-24	0.4881	0.0026	77 437	200	37 798	292 190	669 637	8.65
25-29	0.5201	0.0031	39 439	121	20 513	145 610	377 447	9.57
30-34	0.4195	0.0043	18 805	80	7 890	74 101	231 837	12.33
35-39	0.2652	0.0072	10 835	78	2 874	46 798	157 736	14.56
40-44	0.1735	0.0117	7 884	93	1 367	35 768	110 939	14.07
45-49	0.1805	0.0184	6 424	118	1 159	28 924	75 170	11.70